

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ 1, 2 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 03 дугаар сарын 07

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тус байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 1, 2 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно.

Байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй буюу үнэлгээнд оруулан тооцох боломжгүй дараах арга хэмжээг хяналтаас хасуулах саналтай байна.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авах дэвшилтэд систем /APP/-ийг нэвтрүүлэх, зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авч боловсруулалт хийх, хариу мэдээлэх мэдээллийн төвийг байгуулна.

Үндэслэл: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд уг зорилтод тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Гадаадын иргэн, харьяатын газрын оролцоог тусгаагүй бөгөөд үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, хамтрагч байгууллага нь Боомтын үндэсний зөвлөл, оролцогч байгууллага нь Иргэний нисэхийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар байхаар заасан. Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 261 дүгээр тогтоолоор НҮБ-ын “Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр /goTravel/-ийг хэрэгжүүлэх, мөн энэ талаар авах зарим арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, хөтөлбөрийг зохицуулагч байгууллагаар Хил хамгаалах ерөнхий газар, үндэсний зохицуулагчийн чиг үүргийг Терроризмтой тэмцэх зөвлөлийн Ажлын албанд хариуцуулсан.

2023 оны 1, 2 дугаар сард Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 30 хувь буюу 1.5 оноотой дүгнэгдлээ.

Хэрэгжилт хангалтгүй байгаа нь “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг хэрэгжүүлэх асуудлаар энэ оны 01 дүгээр сарын 03-ны өдөр “Аствишн” ХХК-тай уулзалт зохион байгуулж, туршилтын “Хувилбар 01”-ээс тодорхой хэсгийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх хугацааг шинэчлэхээр тохиролцсон. Үүний дагуу 01 дүгээр сарын 18-ны өдрийн цахим хурлаар үйл ажиллагаанд нэвтрүүлэх хугацааг хойшлуулж, туршилтын нэгдүгээр хувилбартай 02 дугаар сарын 14-ний өдөр, хоёрдугаар хувилбартай 02 дугаар сарын 20-ны өдөр тус тус танилцан системийн тестийг туршсан бөгөөд үйл ажиллагаанд нэвтрүүлж эхлээгүй байгаатай холбоотой.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.9-д “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” ажлын хэрэгжилт удааширч байгаа тул зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэн түргэн шуурхай, нягт хамтран ажиллаж, жилийн эцэст зорилт, арга хэмжээний биелэлтийг бүрэн ханган ажиллах шаардлагатай байна.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР